



ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/07

Бор-Өндөр сум


Багаж, техник хэрэгслийн зардлаас
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.15, 16.5.5 дахь хэсгийн тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бор-Өндөр сумын Улсын бүртгэгч нарын албан хэрэгцээнд зайлшгүй ашиглагдах пос төхөөрөмж худалдан авах 1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөг, өнгөт принтер худалдан авах 708,500 (долоон зуун найман мянга таван зуу) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Зардалд шаардагдах 2,208,500 (хоёр сая хоёр зуун найман мянга таван зуу) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын Багаж, техник хэрэгслийн зардлаас зохих хууль дүрэм, журмын дагуу хяналт тавьж зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (О.Мөнхцэцэг)-д даалгасугай.

ДАРГА



З.УУГАНЖАРГАЛ